

ГЕГЕЛИЙН ГҮН УХААНЫ СУРГААЛЫН ТОВЧ ОЙЛЛОГО

Г.Лодой. МУИС.НШУС.Философийн тэнхим. профессор.

Түлхүүр үгс: Диалектикийн гурвал, туйлын үнэний загвар, туйлын санаа, урлаг, шашин, философийн нэгдмэл чанар,

Өрнө дахины гүн ухааны сэтгэлгээний сонгодог өв уламжлалын хөгжлийн оргил буюу төгсгөлийн үе шатны дүр төрхийг цогц байдлаар төлөөлж чадахуйц сургаалыг боловсруулж, хүмүүн төрөлхтөний оюуны соёлын түүхэнд алдар нэрээ үлдээсэн нэгэн бол германы гүн ухаантан Г.В.Гегель билээ. Тэрбээр оюуны соёлын түүхийн гүнзгий мэдлэгтэй, өөрийн амьдарч байсан үеийнхээ шинжлэх ухааны мэдлэгийн бараг бүх салбарт туурвил бүтээлээ үлдээсэн олон талын боловсролтой онцгой авъяастны нэг байжээ. Берлиний их сургуульд багшилж байхдаа Гегель философийн ухааны мэдлэгийн товчоон, учир зүй, хүн судлал, сэтгэл зүй, гоо зүй, философийн түүх, эрхийн философи, байгалийн философи, дэлхий дахины түүхийн философи, шашны философи зэрэг хичээл зааж байсан нь үүнийг гэрчлэх нэгэн баримт болох биз.

Өнгөрсөн зууны 30-40-өөд оны үед Гегелийн гүн ухааны сургаалыг зөвхөн Герман оронд төдийгүй, Европ дахины соёлыг эзэмшсэн хэн боловч сонирхон судалж марган мэтгэлцэж байсан ажээ. Түүний шавь нараас католик шашны зүтгэлтэн, идеалист, материалист, атеист, коммунист зэрэг янз бүрийн үзэл баримтлалыг шүтэн бишрэгч олон эрдэмтэн, судлаач, зохиолч, улс төрийн зүтгэлтэн төрөн гарсан нь Гегелийн сургаалын цар хүрээ, агуулга, далайц, нөлөөлөл ямар байсны нэгэн үзүүлэлт ажгуу. Оюун ухааны "туйлын үнэнийг" хүмүүн төрөлхтөнд зааж өгөх ариун зорилгыг гүйцэлдүүлэх санаархал нь үл бүтсэн хэдий боловч сэтгэхүйн диалектик сургаалын зохиогчийн эрхийг эдүгээ болтол Гегелийн нэртэй холбон үздэг билээ.

Гегелийн диалектик буюу сэтгэхүйн хөгжлийн тухай гүн ухааны сургаал

Философийн үзэл санааг хүн эзэмшдэг бус, харин хүнийг философийн үзэл санаа эзэмдэх ёстой учир философийн шинжлэх ухаан нь хэн нэгэн хүний зохиомж бус, туйлын үнэн мэдлэгийн систем байх учиртай гэсэн зарчмыг Гегель удирдлага болгож туйлын үнэнд хүрэх арга замыг тодорхойлохыг зорилгоо болгожээ. Туйлын үнэнийг танин мэдэх, ойлгох зөв зам бол диалектик арга мөн гэж Гегель үзээд, түүний диалектик арга бол нотлохуй ба няцаахуйн тулд хэрэглэдэг софист маргах тоглоом бус, хийсвэр, хоосон тодорхойлолтуудыг удирдлага болгодог уламжлалт гүн ухааны сургаал ч бус, харин "сэтгэхүйг шинжлэх ухааны ёсоор залах амин сүнс нь ажээ.

Сэтгэхүйг өөрийнх нь зүй тогтлын дагуу залах, хөгжүүлэх хөдөлгүүр бол зөрчил мөн" гэж Гегель үздэг. Зөрчлийг ердийн эсрэг тэсрэг дүгнэлтүүд мэтээр ойлгох нь хангалтгүй бөгөөд эсрэг тэсрэг дүгнэлт, тодорхойлолт үүсэх, харилцан бие биенээ нөхөн тодорхойлох, улмаар эвсэлдэн

нийлэгжиж нэгэн цогцолбор ойлголт бүрдүүлэх, уг ойлголт дахин шинээр задрах гэх мэтээр тасралтгүй үргэлжлэх үйл явц байдлаар ойлгохын чухлыг Гегель онцлон зааж байв. Энэ утгаараа сэтгэхүйн зөрчилт чанар бол танин мэдэхүйг туйлын үнэнд хөтлөн чиглүүлэгч гол хөдөлгүүр болдог байна.

Туйлын үнэнд хүрэх цорын ганц зөв зам хэмээн үзсэн диалектик аргынхаа механизмыг Гегель сэтгэхүйн гурамсан холбооны зарчмаар тайлбарладаг. Сэтгэхүйн диалектик аргын эхний алхам нь мэдлэгийн агуулгыг задлан шинжилж, тусгаар тусгаар ойлголтуудыг олж илрүүлэх шат байдаг. Дараагийн алхам нь тэдгээрийн харилцан шилжилт, нөхөн гүйцээлтийг тодорхойлох үе шат буюу негатив /урвуу/ диалектикийн үйлдлүүдийг хамаарна. Энэ шатнаа ойлголтуудын харилцан хөрвөх зүй тогтлыг олж илрүүлж, анхан шатны ойлголт, тодорхойлолтуудыг баяжуулах, нөхөн гүйцээх үйлдлүүд гол үүрэгтэй ажээ. Диалектик аргын төгсгөлийн буюу гурав дахь шатнаа сэтгэхүйн үйл явц оюун ухааны төвшинд хүрч зөрчлийн талуудыг тэдгээрийн жинхэнэ нэгдэлд нь цогц байдлаар "амьд" холбоонд нь ухаарснаар "туйлын ойлгоц"-ыг бүрдүүлэх боломжтой болгодог байна.

Сэтгэхүйн үйл явцын энэхүү гурамсан /гурвал/ холбоо нь бодит байдлын ерөнхий төлвийг үнэн зөвөөр ухаарах түлхүүр болох ёстой гэж үзсэн учир Гегель философийн сургаалынхаа хэсэг бүхнийг гурвал бүтэцтэйгээр туурвисан байдаг. Гегелийн сургаалын энэ санааг хялбаршуулсны улмаас түүний диалектик нь үгүйсгэлийн үгүйсгэлийн зарчим буюу үндэслэл /тезис/, үгүйсгэл /антитезис/ тэдгээрийн нэгдэл /синтез/ гэсэн бүдүүвчээр аливаа зүйлийг тайлбарладаг мэтээр ойлгодог зуршил буй нь гэнэн хэрэг юм.

Эсрэг тэсрэг ойлголтуудыг тодорхойлох буюу тезис, антитезисын шат нь сэтгэхүйн биеэ даасан үе шатууд бус, харин диалектик сэтгэлгээний зөвхөн эхний, хийсвэрлэлийн өнгөц хэлбэр бөгөөд ойлголтуудын хөрвүүлгийн үйлдлүүд, тэдгээрийн тусламжтайгаар "туйлын төгс ойлгоц" бүрдүүлэх буюу бодит байдлыг жинхэнэ ахуйд нь цогцолбор ойлголтоор илэрхийлэх үе шатууд нь диалектик сэтгэлгээний гол цөм болдог ажээ. Энэхүү үйл явцыг Гегель хийсвэрээс тодорхойд шилжих шилжилт буюу "туйлын санаа" өөрийгөө ухамсарлаж туйлын үнэнд хүрэх үе шат гэж нэрийдсэн ажээ.

2. Гегелийн философийн систем буюу "туйлын санааны тухай" сургаал

Гегелийн философийн систем нь өмнөх үеийнхээ гүн ухааны болон шинжлэх ухааны сэтгэлгээний ололтуудыг сэтгэхүйн диалектик аргын үүднээс нэгтгэн дүгнэж нэгэн цогцолбор болгосны үр дүн юм. "Түүхгүй бол философи бол хоосон, философигүй бол түүх сохор" гэсэн Кантын дүгнэлтийг Гегель ухаарч, энэ дутагдлыг хэрхэн арилгаж болохыг үзүүлэх зорилгыг философийн системээ байгуулахдаа удирдлага болгосон нь харгаддаг. Хүмүүн төрөлхтөний иргэншлийн бүхий л түүхийн явцад хуримтлагдсан соёлын эрхэмлэлүүдийг өөрийн боловсруулсан аргын үүднээс системчилсний ачаар Гегель Философийн системээ байгуулсан юм гэж хэлж болох талтай.

Гегелийн философийн системийн анхны эх загварын санааг "Оюун ухааны үзэгдлийн тухай сургаал" хэмээх түүний зохиолоос харж болох боловч тал бүрээс нь нягтлан боловруулсан онолын бүдүүвчийг "Логикийн ухаан" хэмээх алдарт зохиолдоо үндэслэсэн буй. Логикийн тухай сургаалдаа Гегель хүмүүн төрөлхтний оюуны соёлын түүхийн үйл явцын дарааллыг онолын сэтгэлгээний буюу оюун ухааны ойлголт, категориудын шүтэлцэлийн зарчмуудтай нягт уялдуулан авч үзэж, бодит байдлын тухай сэтгэхүйн бүдүүвч буюу "туйлын үнэний ойлгоцын" бүтэц нь түүхийн үйл явцын хураангуйлсан илэрхийлэл байх ёстой гэсэн санааг тал бүрээс нь үндэслэхийг оролдсон байдаг.

Гегелийн философийн системийн цөм болох "туйлын санаа" буюу "туйлын үнэний ойлгоц" хэмээх категори нь өөрийнх нь тодорхойлсноор "практикийн болон онолын үзэл санааны нэгдэл, энэ утгаараа, амьдрахуйн ойлгоц ба танин мэдэхүйн ойлгоцын нэгдэл" ажээ. "Туйлын санаа" бол ертөнцийн хаа нэгтээ орших ямар нэгэн бүтээгч хүч буюу "бурхан" бус хүмүүн төрөлхтөний оюун ухаан өөрийгөө, оршихуй ахуйтайгаа нэгдэлд нь ухаарсан "туйлын үнэний ойлгоц"-ын бүдүүвч юм. Чухамдаа ийм ухааралд хүрэх арга зам, зүй тогтлыг философийн ухаан үндэслэх ёстой бөгөөд Гегель өөрийн философийн системийг "туйлын үнэний загвар" мэтээр ойлгож байсан нь гүн ухаантан агсны гол алдаа байсан бололтой.

Оюун ухааны загварт нийцэх бүхэн бодитой байна бодитой орших бүхэн оюун ухаанд нийцэх ёстой гэсэн Гегелийн томъёолол нь Гегель өөрийн философийн системийг оюун ухааны "туйлын үнэний" загвар хэмээн үзэж байсантай холбоотой юм. Гегелийн философийн сургаал нь "туйлын үнэний загвар" үнэхээр мөн байсан бол хүмүүн төрөлхтөн оюун ухааны оргилдоо аль хэдийнээ хүрчихсэн, түүний сургаалыг зөвхөн хэрэгжүүлэх л ёстой байсан билээ. Гэвч Гегелээс хойшхи үеийн хүн төрөлхтөний түүх үүнийг нотолсон ч үгүй, няцаасан ч үгүй, төөрөн будилсаар л эдүгээ хүрсэн билээ.

Философи сэтгэлгээний арга бол философийн сургаалын хураангуйлсан хэлбэр, философийн систем бол сэтгэлгээний аргын дэлгэрэнгүй цогцолбор үр дүн байдаг. Иймд Гегелийн философийн системийг үнэлэхдээ түүний диалектик аргаас салангид авч үзэж болохгүй юм. Сэтгэхүйн гурамсан шатлалаар судлагдхууныг ойлголтоор илэрхийлэх үйл явц сэтгэхүй өөрийгөө ойлгох тэмүүлэл хоёр давхцах ёстой бөгөөд энэхүү давхцалын улмаас оюун ухааны "туйлын үнэн" нь бодит байдлын агуулгыг өөртөө багтааж, түүнийг ойлгох бүдүүвч болох учиртай хэмээн Гегель үздэг.

"Логикийн ухаан" зохиолдоо Гегель "туйлын үнэний" логик бүтцийг томъёолох зорилтыг шийдвэрлэх оролдлого хийснийхээ дараа байгаль нийгмийн бодит байдалд түүний илрэх хэлбэрийг "Байгалийн философи", "Оюун ухааны философи" зохиолууддаа тайлбарласан ажээ. Байгаль, нийгмийн бодит байдалаас "туйлын үнэний" бүтэц, агуулгыг тодорхойлсон бус, харин субстанциал оюун ухааны бүдүүвчээр бодит байдлыг тайлбарласан учир Гегель объектив идеалист гэсэн алдрыг хүртжээ.

Гегелийн философийн систем нь сэтгэхүй, байгаль, нийгмийн үйл явцыг бүхэлд нь хамарсан цогцолбор сургаал бөгөөд түүний философийн үзэл санааг ойлгох хамгийн чухал хэсэг бол туйлын оюун санааны тухай сургаал юм. Түүний үзлээр, туйлын оюун санаа өөрийгөө танин мэдэх үйл

явц урлаг, шашин, философи гэсэн гурван шатлалтай хэрэгжих учиртай ажээ. "Туйлын оюун санааны гурван ертөнц нь агуулгын хувьд адил боловч объект буюу туйлын оногдохуйг ухаарах хэлбэрээрээ л бие биенээсээ ялгарна" гэж Гегель нотолсон байдаг. Оногдохуйг мэдэрхүйн бясалгалд ухаардаг нь урлаг, төсөөлөхүйн хэлбэрээр ойлгодог нь шашин, ойлголтоор танин мэддэг нь философи ажээ. Гэвч урлаг, шашны аль аль нь туйлын оюун ухаан өөрийгөө танин мэдэх төгс хэлбэр болж үл чадах ба зөвхөн философи л тэрхүү төгс хэлбэр болдог гэж Гегель үздэг. Философи бол урлаг, шашны аль алиных нь өрөөсгөл талыг арилгаж тэдгээрийн агуулгыг ойлголтоор нэгтгэн илэрхийлдэг учир "туйлын үнэний" төгс илэрхийлэл болдог байна.

Философи юмс, үзэгдлийг ойлголтын төвшинд тайлбарладаг боловч тодорхой шинжлэх ухааны ололтуудыг үл ойшоодог бус, харин тэдгээрийн тусламжтайгаар оюун ухааны түгээмэл "туйлын бүдүүвчийг" олж тогтоодог гэсэн чухал санааг Гегель дэвшүүлсэн юм. Шинжлэх ухааны танин мэдэхүйн олон зуун жилийн түүх, философи сэтгэлгээний түүх бол туйлын оюун ухаан өөрийгөө танин мэдэж "төгс үнэн" буюу "туйлын санаа"-ны хэлбэрийг олох шим хөрс, амьдрах орчин нь болдог байна.

Орчлонгийн мөн чанар, оршихуйн бүтэц тогтолцоо, ойлгохуйн хууль зүй тогтлыг оюун ухааны ертөнцөөс тайлбарлаж, хүмүүн төрөлхтөний өмнө "туйлын үнэний" бүдүүвчийг толилуулах санаанд багтамгүй том зорилтыг нэгэн биеийн хүчээр шийдвэрлэх гэсэн Г.В.Гегель хэмээх германы гүн ухаантан агсны философийн энэхүү товч ойллого нь түүний сургаалын өргөн цар хүрээтэй, олон талт баялаг агуулгын зангилаа болох сэтгэлгээний диалектик арга, гүн ухааны сургаалын системийнх нь бүтцийг өнгөцхөн дурдсан оролдлого төдий зүйл болно.

Иймд Гегелийн сургаалыг авах гээхийн ухаанаар шүүн тунгаах аваас ухааралд өгөх зүйлс, учир нь үл ойлгогдох битүүлэг санаа, өөрийн үеэ өмгөөлөн зөвтгөх үзэл, өөрчлөлт хөгжлийн зайлшгүйг нотлон харуулах оролдлогын аль алиныг олж үзэж болох тул идеалист, материалист, харгис, дэвшилтэд гэсэн ангилалаар үнэлэхийг оролдсонгүй. Философийн сургаалыг хэн нэгэн хүний үнэлэмжээр бус, уншигч өөрийнхөө ойлгоцоор ухаарах нь илүү үнэ цэнэтэй байх учиртай ажгуу.